

**“САВ, БАГЛАА БООДОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1.	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго: Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> - улсын болон орон нутгийн төсөв; - гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж; - хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн эх үүсвэр; - гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт; - бусад эх үүсвэр. 			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хөтөлбөр нь 2017-2021 онд хэрэгжинэ.			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, БОАЖЯ, МХЕГ, СХЗГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ.			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Хөтөлбөрийн хүрээнд 3 зорилт дэвшүүлсэн.</p> <p>Зорилт 1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх;</p> <p>Зорилт 2. Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах;</p> <p>Зорилт 3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх.</p>			
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	-		
		Үүнд:	Төсөв /2020/	Гүйцэтгэл	Хувь
		Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /сая төг/	-	1,327.3	-
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Арга хэмжээний биелэлт: Хөтөлбөрийн 3 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 29 үйл ажиллагаа төлөвлөгдсөн.			
	Зорилт 1	Хавсралтын 2-5 дугаар хуудас			

	Зорилт 2	Хавсралтын 5-14 дүгээр хуудас			
	Зорилт 3	Хавсралтын 14-18 дугаар хуудас			
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p><u>Ололт:</u></p> <ul style="list-style-type: none"> - Улс орон даяар “Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөний дүн өрнүүлж, хуванцар савны хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх аюулын талаар хот хөдөөгийн хүн амд сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн. - Өмнөх онд өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрууд болон хамтран хэрэгжүүлэгч яам, агентлагаас тайлан авч, нэгтгэлд тусгаж тайлангийн боловсруулалтыг сайжруулсан. <p><u>Дутагдалтай тал:</u></p> <ul style="list-style-type: none"> - Тайланд Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн 7.2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгаагүй. <p><u>Зөвлөмж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөр хэрэгжих хугацаа 2021 онд дуусах тул хэрэгжилтийг эрчимжүүлэхийг Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус; - Засгийн газрын 2020 оны 206 дугар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн тайлагнахыг дээрх газруудад; 			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас уг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэж, төсөвт зардал тусгуулах санал сүүлийн 3 жил дараалан хүргүүлсэн боловч шийдэгдэхгүй хасагдсан болно.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Зорилт	1	2	3
		Дундаж үнэлгээ 83.76%	75.0	85.6	87.1
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			
		-			

Сав, баглаа боодол хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хавсралт

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх						
1	1.1. Сав, баглаа боодол, хаяг шошго үйлдвэрлэх, тэдгээрийн хаягдлыг дахин боловсруулах зориулалт бүхий үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2017 - 2021	0		Засгийн газрын 168 дугаар тогтоолоор хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын дотоодод үйлдвэрлэх боломжгүй 21 чиглэлийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд Гаалийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг баталсан. Тус жагсаалтад Сав баглаа боодол, савлах үйлдвэрийн нийт 27 тоног төхөөрөмж багтсан бөгөөд 2020 онд уг тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, хугацааг сунгах төслийг боловсруулан, ЖДҮҮХХБЗГ-аар дамжуулан Сангийн яам болон гаалийн тарифын зөвлөлд хүргүүлсэн боловч СЯ-аас тусгай зохицуулсан хууль эрх зүйн үндэслэлгүй тул хугацааг сунгах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. ЖДҮҮХХБЗГ-аас Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч Татварын багц хууль батлагдсантай холбогдуулан татварыг давхардуулан ногдуулах боломжгүй гэсэн хариу өгсөн.	70%
2	1.2. Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа болон хуучин савны устгал, шилжилтийг хянах, бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;	2017 - 2021	0		Мэдээллийн сангийн өгөгдөлтэй холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэв: 1. Улаанбаатар хотод 7980 өрхийн хуванцар савны хэрэглээ, Хэнтий аймагт хүнсний зориулалтын сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхэлж буй ААН-ийн судалгааг тус тус хийв. 2. Монголын Хүнсчдийн Холбоо нь ХХААХҮЯ-тай байгуулсан гэрээний дагуу 21 аймаг, Улаанбаатар хотын 4,472 өрхийг хамруулан, SPSS программ ашиглан зориулалтын бус химийн савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааг гүйцэтгэж, судалгааны тайланг хүлээлгэн өгсөн. 3. Архангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Ховд, Дундговь, Сүхбаатар, Завхан, Хэнтий, Орхон, Өвөрхангай Хөвсгөл аймаг хүнсний зориулалтын сав олгон, зориулалтын бус хуванцар сав, нийлэг хальсан уутыг устгалын комисст хүргүүлэх, устгалд оруулах, сав баглаа боодлын хаягдлыг цуглуулан зохион байгуулалттайгаар УБ хот руу нийлүүлэх, модон торх, зэс, цайран шанага зэрэг эко савны хэрэглээг дэмжих, ургамал хамгааллын бодис, бордоо нийлүүлэгч ААН-д химийн бордоо, бодис хор гербицидийн савыг буцаан тушаах ажлыг гэрээний үндсэн дээр тус тус хэрэгжүүлсэн.	70%
3	1.3. Хүнсний зориулалтын бус саван	2017 - 2021	0		“Хүнсстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэг, Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл-ийн стандартын төслийг тус тус боловсруулсан. Төсөлд	100%

	дээр анхааруулах тэмдэглэгээ тавьдаг болох эрх зүйн зохицуулалт бий болгох;			холбогдох байгууллагаас санал авч, СХЗГ-ын Хүнсний стандартчилалын Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. СХЗГ-ын даргын 2020 оны 07 сарын 01-ний Т-27 тушаалаар “Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг” MNS 6848:2020 Үндэсний стандарт, Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл MNS ISO TS 22002-4:2020 Үндэсний стандартыг тус тус батлуулсан.	
4	1.4. Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээг хамарсан техникийн зохицуулалт гаргах, олон улсын стандартуудыг нутагшуулах, одоо мөрдөж байгаа стандартуудыг шинэчлэх;	2017 - 2021	0	1. Европын холбооны хүнстэй харьцах материалын аюулгүй байдлын шинжилгээний аргын EN 1186-1:2002 (WI=00194065), EN 1186-3:2002 (WI=00194067), EN 1186-9:2002 (WI=00194073) дугаартай 3 стандартын сорил, баталгаажуулалтыг гүйцэтгүүлэхээр ХХААХҮЯ нь УМЭАЦТЛабораторитой 200619/226 дугаартай гэрээ байгуулж ажиллаж байна. Гүйцэтгэлийг 2021 оны 6 сард хүлээн авна. 2. ХХААХҮЯ нь Хүнд даацын шуудайн стандартыг шинээр боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг "Эс эм контейнер байг" ХХК-тай байгуулан, гүйцэтгэлийг хүлээн авсан. 3. “Хүнсний зориулалтын хуванцар материалын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ын төслийн хамрах хүрээ, үндсэн бүтцийг тодорхойлж, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчдээс санал авч, нэгтгэсэн.	70%
5	1.5. Улсын хилээр хүнсний зориулалтаар нэвтрүүлэхийг зөвшөөрсөн сав, баглаа боодол, ахуйн барааны жагсаалт гаргах, барааны ангиллын код тодорхойлох, батлуулах;	2017 - 2021	0	Европын Холбоо, АНУ-ын хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтыг судалж, хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэлд ашиглахыг зөвшөөрсөн мономер болон үндсэн бодисын жагсаалтыг боловсруулав. Эдгээр бодисын Барааг тодорхойлох кодлох уялдуулсан системийн 3901-4017 ангилалтай уялдуулах ажлыг эхлүүлсэн.	70%
6	1.6. Сав, баглаа, боодлын аюулгүй байдлыг хангах, хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжийн хөрөнгийг уг салбарт зарцуулахыг дэмжих.	2017 - 2021	0	АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төсөл, "Адра-Монгол" ОУБ, “Дэлхийн зөн- Монгол” ОУБ, НҮБ-ын ХХААБ-ын “SECIM” төсөл, Канад сан, GIZ-ийн ЭТИС төсөл, Францын хүнсний тусламжын сан зэрэг 10-аад олон улсын байгууллагын хөтөлбөр, төслийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хамтран ажилласан.	70%
2. Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах					

7	2.1. Хүнсний сүлжээний бүх үе шатанд ашиглах сав, баглаа боодол болон хүнстэй шууд харьцах үйлдвэрийн болон ахуйн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хаяг, шошгын зөрчлийг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх, уг үйл ажиллагаанд тавих төрийн болон дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх;	2017 - 2021	0	<p>1. ЕХ болон АНУ-ын хууль тогтоомжийг судалсны үндсэн дээр хүнстэй хүрэлцэж буй хуванцар гадаргуугаас хүнсний бүтээгдэхүүнд нэвчиж, шилжиж болзошгүй 885 химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний жагсаалтын төслийг боловсруулав.</p> <p>2. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 473, хүнсний үйлдвэр 141, хүнсний худалдааны 577, нийт 1191 аж ахуйн нэгж, иргэнийг шалгалтад хамруулж, 54 зөрчил илрүүлэн, 49 буюу 91 хувийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. 3. УБ хотод үйл ажиллагаа явуулж байгаа Согтууруулах ундааны 7 үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн урсгал шугам болон эцсийн бүтээгдэхүүний савлалт, хаягжилтад хяналт тавьж, шошгын стандартын зөрчилтэй ААН-д зөвлөмж өгч ажилласан. 4. Архангай аймагт 11 ААНБ, 6 иргэний 16 нэр төрлийн 57 бүтээгдэхүүн болон хаяг шошгололтонд тохирлын үнэлгээ хийж баталгаажуулан, 16 тохирлын гэрчилгээ олгосон. 5. Архангай, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Орхон, Сэлэнгэ, Ховд, Завхан аймагт ЕБС, цэцэрлэгийн дэргэдэх гал тогоо, үдийн цайны газарт хуванцар савны хэрэглээг бүрэн зогсоож, худалдааны газраар худалдаалж буй хуванцар саванд хяналт шалгалт хийх, зориулалтын бус савыг худалдаанаас татан авах, зориулалтын саваар солих, тэмдэглэгээний талаар зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмж хүргүүлж ажиллав.</p>	90%
8	2.2. Сав, баглаа боодлын аюулгүй байдлыг хангах, хаяг шошгын бичлэг үнэн зөв эсэхийг баталгаажуулдаг болох, үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр түншлэгч орнууд, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлж, олон улсын сайн туршлагыг нутагшуулах;	2017 - 2021	0	<p>1. ЭМЯ-ны дэргэдэх Хүнсний сав баглаа боодол, шошгын орон тооны бус Зөвлөлийн үйл ажиллагааны журам, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав баглаа боодол шошгод үнэлгээ хийсэн шинжээчийн дүгнэлт гаргах загвар маягыг тус тус баталсан. 2. АХБ-ны 2025 он хүртэл хэрэгжих зээл, буцалтгүй тусламжийн жагсаалтад "Хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдлыг хангах" талаар төсөл хэрэгжүүлэх саналыг боловсруулж, хэлэлцүүлсэн. 3. Европын сэргээн босголт хөгжлийн банкны "Жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэмжих баг"-тай хамтран хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулах олон улсын сайн туршлагыг нутагшуулах сургалт, хэлэлцүүлэгт 200 аж ахуйн нэгжийг хамруулсан. 4. АХБ-ны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт" төсөл, "Адра-Монгол" ОУБ, "Дэлхийн зөн- Монгол" ОУБ, НҮБ-ын ХХААБ-ын "SECIM" төсөл, "Зах зээл, бэлчээрийн удирдлагын хөгжил" төсөл, Канад сан, GIZ-ийн ЭТИС төсөл, Францын хүнсний тусламжийн сан зэрэг 10-аад олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлтэй хамтран сав, баглаа, боодлын аюулгүй байдал, зохистой хэрэглээний талаарх 15 гаруй удаагийн сургалтыг Баян-Өлгий, Говь-Алтай, Хэнтий, Төв аймгийн 1500 гаруй иргэн ААН-ийг хамруулан зохион байгуулсан. 5. Хөвсгөл аймагт НҮБ-ын ХХААБ-ын "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл", Ногоон алт төслийн дэмжлэгтэйгээр сүү, цагаан идээ үйлдвэрлэж байгаа хоршоодод хүнсний зориулалт бүхий сав баглааг хэрэглэх, бүтээгдэхүүний хаяг шошгыг стандартын шаардлагад нийцүүлэн хэвлүүлж хэрэглэх талаар гарын авлага, зөвлөмж боловсруулан тараасан.</p>	90%
9	2.3. Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж байгаа картонон хайрцаг, нэг удаагийн	2017 - 2021	0	<p>1. Монгол улсын хүн амын ахуйн хэрэглээнд ашиглаж буй хүнсний бус зориулалтын савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааг "Монголын хүнсчдийн холбоо" төрийн бус байгууллага гүйцэтгүүлэхээр 201110/07/470 дугаартай гэрээг байгуулж, дараах үр дүнд хүрсэн: I. Химийн бодисын хуванцар сав (пестицидийн цэнхэр сав, барилгын материал, замасканы сав, малын эм, бэлдмэлийн сав)-ны ахуйн хэрэглээний түвшинг тогтоох судалгааг Googleform судалгааны программ хангамжийг ашиглан</p>	90%

	хэрэглээний хэрэгсэл болон ус, ундааны хуванцар савны ариун цэвэр, эрүүл ахуйн байдлын талаар тандан судалгаа явуулж дүнг нийтэд мэдээлэх;			цахимаар гүйцэтгэх аргачлалыг боловсруулсан. II. Химийн бодисын хуванцар савны ахуйн хэрэглээний түвшинг тогтоох судалгааг асуумжийн дагуу 21 аймаг, Улаанбаатар хотын судалгаанд хамрагдах өрхийн тоог 1%-иар тооцож, 4,472 өрхийг судалгаанд хамруулж, үр дүнг SPSS программ ашиглан боловсруулсан. III. Судалгаанд хамрагдсан өрхийн шинж байдал, хүнсний зориулалтын савны хэрэглээний түвшин, хүнсний зориулалтын савны тухай мэдлэг, ойлголт, зориулалтын бус хуванцар савны хэрэглээний сөрөг нөлөөний талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, хүнсний зориулалтын хуванцар савны хэрэглээг бууруулах боломж арга зам, устгал гэсэн 6 үндсэн сэдвийн хүрээнд мэдээллийг бэлтгэсэн. Зориулалтын бус химийн савны хэрэглээний түвшинг бодитой тодорхойлсон. 2. 2. МХЕГ-ын Сорилтын нэгдсэн лабораторид хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газрын ашиглаж буй нийлэг гялгар уут, нэг удаагийн аяга, хоол савладаг бакет, талхны уут зэрэг 11 төрлийн 38 дээжинд 8 үзүүлэлтээр /микробиологийн үзүүлэлт: нянгийн тоо, колиформ, Staph.aureus, Salmonella, Listeria monocytogenes, E.Coli, химийн үзүүлэлт: рН, хүчил шүлтэд тэсвэрлэх чадвар/ шинжилгээнд хамруулахад 95,2% стандартын шаардлага хангасан байна.	
10	2.4. Эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах зориулалтын хөргөлттэй вагон, үр тарианы контейнер, автотээврийн хэрэгсэл, агуулах, зорь, хөргүүрийн камерын хангамжийг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг чиглүүлж өргөжүүлэх;	2017 - 2021	0	1/ Ховд аймгийн Жаргалант суманд төсвийн хөрөнгөөр төмс, хүнсний ногооны механикжсан 1000 тонн багтаамжтай агуулах, зоройг 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. 2/ “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам”-ын төслийг боловсруулж, батлуулсан. Тээвэр зуучийн мэдээллийн удирдлагын нэгдсэн систем www.teeverzuuch.mn -д түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд зохицуулалтыг тусгаж өгөв. Онцгой нөхцөл байдлын үед хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг хот доторхи, хот хооронд, импорт экспортын авто тээврээр тээвэрлэхэд батлагдсан түр журмын хүрээнд QR код ашиглан шуурхай зохион байгуулж байна. Мөн коронавируст халдварын цар тахлын үед хүнсний хангамж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай” хамтарсан тушаалын төслийг боловсруулж, батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 3/ Тээвэр зуучийн мэдээллийн удирдлагын нэгдсэн системд ачаа илгээгч болон хүлээн авагч, тээвэрлэгчийн ачааны мэдээллийг Барааг тодорхойлох кодлох уялдуулсан системийг ашиглан гүйцэтгэх талаар санал боловсруулж систем эзэмшигчид хүргүүлсэн болно.	70%
11	2.5. Түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодлын уян хатан, бат бөх чанар, найрлагыг судлах, тэмдэглэгээг баталгаажуулах, чанар, эрүүл ахуйн үнэлгээ хийх лабораторийн хүчин чадлыг	2017 - 2021	0	1. “Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг” MNS 6848:2020 Үндэсний стандартыг батлуулж, олон нийтэд сурталчлав. - ХАБҮЛЛаборатори нь АНУ-ийн ANAB олон улсын байгууллагын итгэмжлэлд хамрагдаж, 60 үзүүлэлтээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөж, итгэмжлэгдсэн. Хуванцар сав баглаа боодолд: хартугалга, кадми, зэс, цайрын үзүүлэлт тодорхойлох шинжилгээний арга хамрагдсан болно. 2. Орхон аймгийн МХГ-ын лабораторид цэвэр усны 3 үйлдвэрийн усны савыг шинжилгээнд хамруулан, лабораторийн дүнг тандалт судалгаанд ашиглаж, усны үйлдвэрт эрүүл ахуйн дадлын зөвлөмж өгч ажилласан. 3. Өвөрхангай аймгийн МХГ-ын Сорилтын нэгдсэн лабораторид 39 нэр төрлийн хуванцар сав баглаа, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнийг 64 үзүүлэлтээр шинжилсэн. 4. Сүхбаатар аймгийн 9 сумын хүнсний чиглэлийн 33 газарт ашиглагдаж буй шинжилгээ баталгаажилтгүй нэг удаагийн хоолны хэрэгсэл, нийлэг уутнаас дээж авч нэгдсэн лабораторид шинжлэн, шаардлага хангахгүй нийлэг хальсан уутыг буцаан татуулж, зөвлөмж хүргүүлж ажиллав. 5. Хөвсгөл аймгийн хүнсний үйлдвэр, цех, худалдааны газрын ашиглаж буй 10 нэр төрлийн хуванцар савнаас 39	100%

	нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах;			дээж авч, шинжилгээ хийхэд нийлэг уут, картонон хайрцаг, хуванцар сав нь PH, формальдегид, нян судлал, хүнд металлын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнд, холбогдох стандартын шаардлагыг хангасан дүнтэй гарсан. Тандалт судалгаагаар илэрсэн 87 зөрчлийн 36.8%-ийг газар дээр нь арилгуулж, хугацаатай 9 албан шаардлага хүргүүлсэн.	
12	2.6. Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэн, ажилтнуудыг чадавхжуулах зэрэг арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;	2017 - 2021	0	1. ЕХ-ны стандартад тулгуурлан Сав, баглаа боодлын аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээний аргын лабораторийн сорилыг гүйцэтгэж байна. Гэрээний дүнг 2021 оны 06 сард хүлээн авна. 2. Медимпэкс Интернэшнл компаниас “Ажилентын Демо Төв” ашиглалтад орж, HPLC болон GC/MS багаж дээр сав баглаа боодлын аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох асуудлаар лабораторийн мэргэжилтнийг давтан сургах боломж бүрдэв.	70%
13	2.7. Хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээлэл болон сэрэмжлүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх, сурталчлах;	2017 - 2021	0	1. Органик хүнсийг гэрчлэх тэмдэг, түүнийг хэрэглэх, таних, хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг багтаасан богино хэмжээний видео танилцуулга, 1920x1080 нягтаршилтай дүрстэй Mp4, Mpg2 форматтай анимешинийг youtube, wetransfer-т байршуулан, шторкыг facebook болон олон нийтийн цахим хуудаснуудад 50 удаагийн давтамжтай идэвхжүүлэлт хийж, “Өлзий”, “Сүлд” телевизээр 4 өдөр 16 удаагийн давтамжтай цацалт хийсэн. 2. Баталгаажуулаагүй, бүртгэлгүй, хуурамч хаяг шошготой органик бүтээгдэхүүний сурталчилгааг хориглох тухай ХХААХҮЯ-ны ТНБД-ын албан бичгийг томоохон 29 телевиз, радио, сайтуудад хүргэж, мэдээллийн үнэн зөв байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг авч хэрэгжүүлсэн. 3. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв зориулалтын бус хуванцар савны талаарх 1 минутын анимешнийг олон нийтэд хүргэв. 4. ХААИС-тай хамтран “Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний /мах, сүү/ хэрэглээ, сав баглаа боодол” сэдвийн дор хуванцар савны тэмдэглэгээ, хор хөнөөлийн цахим сургалтыг 2 удаа зохион байгуулж, 4456 иргэн хандалт хийсэн. 5. Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр Дархан-Уул, Дорноговь, Увс, Сүхбаатар, Сэлэнгэ, Өвөрхангай, Хэнтий, Ховд, Хөвсгөл аймагт орон нутгийн ТВ, радио, ЗДТГ-ын цахим хуудсаар 163 удаагийн давтамжтай цахимаар, 19700 ширхэг сурталчилгааны материалыг зөвлөмж, мэдэгдэл, постер, брошур зурагт хуудас хэлбэрээр давхацсан тоогоор 60240 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд хүргэж ажилласан байна.	90%
14	2.8. Хүний эрүүл мэндэд хортой, сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон хүнсний зориулалтын бус сав, баглаа боодол, хэрэгслийг хүнсний худалдаа, үйлчилгээ,	2017 - 2021	0	1. Аймаг, Нийслэлийн асуудал хариуцсан газар, хэлтсээс хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, иргэдэд хүний эрүүл мэндэд хортой зориулалтын бус савны талаар зөвлөмж зөвлөгөөг тухай бүр өгч, гарын авлага материалаар ханган ажиллаж байна. 2. Улаанбаатар хотын хэмжээнд хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хүнсний зориулалтын бус хуванцар сав, хэрэглэлийг ашиглах зөрчлийг бүрэн таслан зогсоож, ЕБСургуулийн 90 хувь хүнсний зориулалтын сав хэрэглэж байна. Архангай, Говь-Алтай, Баян-Өлгий, Дундговь, Дорноговь, Өвөрхангай, Увс, Төв аймгийн ЕБСургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвүүдийн гал тогоонд стандартын шаардлага хангасан сав хэрэглэж, зориулалтын бус савыг хэрэглээнээс бүрэн халсан байна.	100%

	нийтийн хоол, сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг зэрэг газар хэрэглэхийг хориглох, өрхийн хэрэглээнээс халах арга хэмжээ авах;			3. Дундговь аймгийн хүнсний үйлдвэр, цехийн 90%, Өвөрхангай аймгийн худалдаа үйлчилгээний газруудад 80% нь хүнсний зориулалтын сав, баглаа боодол ашиглаж байна. 4. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 74 аж ахуй нэгжид хяналт шалгалт хийж, шаардлага хангаагүй, зориулалтын бус 16 төрлийн 8466 ширхэг сав баглаа боодлыг устгав.	
15	2.9. Хүнсний зах, худалдааны төв, үйлдвэр, үйлчилгээний газруудыг эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын тор, бидон, зориулалтын сав, баглаа боодол, агуулах, хөргүүр ашиглахыг шаардах, зөв дадлыг хэвшүүлэх;	2017 - 2021	0	1. Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хэвшүүлэх зохистой дадлын төслийг 14 чиглэлийн асуудлыг хамруулан боловсруулав. 2. Улаанбаатар хотын хүнсний зах, худалдааны төв, үйлдвэр, үйлчилгээний 1022 аж ахуйн нэгжид шаардлага хангасан стандартын тор, бидон, зориулалтын сав баглаа боодлын хэрэглээ, агуулах, хөргүүр ашиглалтын зөв дадлыг хэвшүүлж байгаа талаар хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан, 181 аж ахуйн нэгжид үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулсан. 3. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хэнтий, Увс, Завхан аймгууд сав баглаа боодлын аюулгүй байдлын талаар тандалт хийж, гарсан зөрчил, дутагдлыг арилгах талаар мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажилласан ба нийт зөрчлийн 82% нь буурсан байна.	90%
16	2.10. Химийн бодисын хуванцар сав, торх, канистерыг хүнсний зориулалтаар ашиглуулахгүй байх зорилгоор “Шинэ санаа-шилдэг шийдэл” уралдаан зарлаж, дүнг нийтэд сурталчлах, түгээх;	2017 - 2021	0	1. "Мөнгөн богц" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хөтөлбөр, шаардагдах санхүүжилтийн хуваарийг агуулсан Сайдын тушаалын төслийг боловсруулсан боловч Ковид-19-ийн нөхцөл байдалтай холбоотой тэвчиж болох зардлын ангилалд хамааралтай тул санхүүжүүлэх боломжгүй гэсэн чиглэл өгсөн. 2. Өмнөговь, Сүхбаатар, Төв аймагт Мөнгөн богц" арга хэмжээг зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжийг шагнаж урамшуулсан. 3. Хөвсгөл, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай, Булган, Өвөрхангай аймгууд “Түншлэл-2020” “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд "Шилдэг сав баглаа, боодол" номинацид шалгаруулах, шагнах модны ур, мал аж ахуйн түүхий эд ашиглан ур ашиглаж хийсэн модон хөнөг, хутгуур, халбага, хөхүүр, борви үйлдвэрлэн борлуулж буй иргэдийн үйл ажиллагааг сурталчилах ажлы амжилттай зохион байгуулсан. 4. Өвөрхангай аймгийн Арвайхээр сум хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах бэлтгэн нийлүүлэх “Цэмцгэр” төвийг байгуулан, цаашид гялгар уут, хуванцар савыг дахин боловсруулж, төрөл бүрийн хайс, шон, цэцгийн сав гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж байна. Хогоо ангилан ялгаж хийх зориулалтын сав үйлдвэрлэн, айл өрх, орон сууц, ААНБ-ын хогийн цэгт байрлуулан, гялгар уут, хуванцар савыг ялган авч, түүхээ эд бэлтгэлийн ажлыгаа жигдрүүлэхээр ажиллаж байна.	70%
17	2.11. Хүнс үйлдвэрлэгчдэд хаяг шошгын стандарт мөрдүүлж хэвшүүлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэхээс сэргийлэх зорилгоор	2017 - 2021	0	1. “Хүнсний сав, баглаа боодлын үйлдвэрлэлд тавигдах шаардлага”, “Хүнс тэй хүрэлцэхэд аюулгүй гэмдэг”-ийн стандартыг хэвшүүлэх цахим сургалтын хөтөлбөр, схемийг баталж 5 удаагийн давтамжтай 19 байгууллагын 83 хүн хамруулж цахим сургалтыг зохион байгуулав. 2. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймгийн 726 иргэн, аж ахуйн нэгжид хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын чана, аюулгүй байдлын чиглэлээр цахим, болон танхимын сургалтад хамруулав.	90%

	сурталчилгааны арга хэмжээ авах;					
18	2.12. Зөв шошготой, чанар, стандартын шаардлага хангасан сав, баглаа боодлын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хүргэх ажлыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;	2017 - 2021	0		1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-09, дүгээр тушаалаар батлагдсан “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”, А-180 дугаар тушаалаар батлагдсан “Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын дагуу органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn –г ашиглалтад оруулсан. 2020 оны 12 сарын байдлаар Органик хүнсний бүртгэл, мэдээллийн www.organic.gov.mn цахим санд бүртгэлтэй, эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан дотоодын үйлдвэрийн 382 органик, шилжилтийн үеийн 238, импортын 25 органик хүнсийг зах зээлд нийлүүлсэн байна. 2. Нөөцийн мах бэлтгэсэн 31 аж ахуйн нэгжид “GS1 систем, зураасан код”-ны сургалтыг зохион байгуулж, “Нөөцийн мах Үхэр”, “Нөөцийн мах Хонь”, “Нөөцийн мах Ямаа” гэсэн 13 орон бүхий зураасан “Бар код”-ыг авлаа. Нөөцийн махны сав баглаа боодлын хаяг шошгод орсон өөрчлөлтийг Сангийн яамны харьяа Гааль, татвар, санхүү мэдээллийн технологийн улсын үйлдвэрийн газрын мэдээллийн санд бүртгүүлсэн. 3. Орхон аймгийн 12 ААН бар кодыг бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгоны мэдээлэлд оруулав.	100%
19	2.13. Хүнсний зориулалтын бус хуванцар сав, гялгар уутны хэрэглээнээс татгалзах аян өрнүүлэх, “Хөх сав, канистергүй аймаг, дүүрэг, сум, хороо” хөдөлгөөн өрнүүлж, жил бүр дүгнэж мэдээлдэг болох;	2017 - 2021	0		1. Аймаг, Нийслэлийн "Сав баглаа боодол" дэд хөтөлбөрийн хүрээнд "Хөх сав, канистергүй аймаг, дүүрэг, сум, хороо" хөдөлгөөнийг өрнүүлж, ажиллаж хэвшсэн. 2. Баян-Өлгий аймагт хуванцар савыг хэрэглээнээс халсан 3 сумыг шагнаан урамшуулах, Говь-Алтай аймаг “Хуванцар шанагагүй айл өрх” аян сумдын иргэд, малчдын дунд өрнүүлж, төмөр шанага, халбагыг хэрэглэж хэвших, Говьсүмбэр аймагт судалгаанд хамрагдсан өрхийн 70 хувь нь зориулалтын ган төмөр сав хэрэглэж хэвшсэн, Дорноговь аймгийн 5 багийн 175 өрх ундны усны саваа төмөр саваар шинэчилэн, аймгийн нийт өрхийн 26% нь хөх савыг хэрэглээнээс халсан, Орхон аймагт төсвийн хөрөнгөөр тодорхой арга хэмжээ зохион байгуулсан, Өвөрхангай аймгийн бүх сумдын төсөвт байгууллагууд зориулалтын бус савыг хүнсэнд хэрэглэхээс татгалзаж хэвшсэн, Сүхбаатар аймаг “Аргил сувд” ХХК-ний 700 ш хүнсний зориулалттай усны савыг хөнгөлөлттэй нөхцлөөр иргэдэд борлуулсан, Увс аймгийн төвийн нийт өрхийн 70% хувь, сумын түвшинд 50% нь хөх сав, канистерээс бүрэн татгалзсан, Хөвсгөл аймгийн зөврийн болон гүний нийт 119 ус түгээх худгийн 59% нь зориулалтын цэвэр усны савтай болсон, Хэнтий аймгийн нийт өрхийн 70% нь хүнсний зориулалтын сав хэрэглэж хэвшсэн, Сэлэнгэ аймаг “Даавуун уутны бүтээлийн уралдаан” зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг аймгийн томоохон худалдаа үйлчилгээний газруудаар худалдаалах сувгийг нээсэн зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.	90%
20	2.14. Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээг хэрэглээнд хэвшүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авах;	2017 - 2021	0		1. “Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэг MNS 6848:2020 стандартын төслийг холбодох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, хэлэлцүүлэн СХЗГ-ын даргын 2020 оны 07 сарын 01-ний Т-27 тушаалаар батлуулж, СХЗГ-ын Мэдээллийн санд байршуулсан ба www.estandart.gov.mn цахим хуудаст хандан, цахимаар худалдан авах боломжийг бүрдүүлсэн. 2. Улаанбаатар хотод хуванцар савны хэрэглээ, түүний хор хөнөөл, хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдгийн талаар 2010 иргэн, ААНБ хамруулан сургалт зохион байгуулж, байр, сууц, гэр хорооллын 42654 өрхөд гарын авлага тарааж, 239 худагт зөвлөмж мэдээллийг байршуулав. 3. Хүний эрүүл мэндэд хуванцар савны үзүүлэх сөрөг нөлөөний талаар Өнөөдөр сонинд “Хүн төрөлхтөн хуванцарт идүүлж байна” сэдэвт нийтлэл, МҮОНТВ, Ийгл телевизтэй хамтран 2 удаа “Хуванцрын хэрэглээ, аюулгүй байдал” зорилтот нэвтрүүлэг, иргэд,	100%

				малчдад зориулан Монголын радиогоор 7 хоног бүр хуванцрын сөрөг нөлөөллийн тухай давтамжтай нэвтрүүлгээр мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулсан.	
21	2.15. Хүнсний чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан сав, баглаа боодлын эрүүл ахуй, чанар стандарт, аюулгүй байдлын талаар тусгайлан сургалт зохион байгуулах;	2017 - 2021	0	Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хэвшүүлэх зохистой дадал, “Хүнсний сав, баглаа боодлын үйлдвэрлэлд тавигдах шаардлага”, “Хүнсгүй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг”-ийн стандартыг хэвшүүлэх сургалт, хэлэлцүүлгийг Google Classroom аппликейшн ашиглан цахим хэлбэрээр 83 оролцогчдийг хамруулан зохион байгуулав. Хавсралт : 2 файл	100%
22	2.16. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн зөөвөрлөх, хадгалахад ашиглаж байгаа зориулалтын бус савыг зориулалтын саваар солих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	2017 - 2021	0	1/ Баянхонгор аймгийн Баянхонгор, Эрдэнэцогт, Өлзийт, Баян-Овоо сумын 2800 өрхийн сүү, сүү бүтээгдэхүүн, ундны усыг хадгалах, тээвэрлэх зориулалтаар ашиглаж буй химийн хуванцар 3 савыг хүнсний зориулалтын 2 саваар солиход шаардагдах 40 литрийн багтаамжтай 56000 ширхэг төмөр бидоныг худалдан авахад шаардагдах 840.0 сая төгрөгний 80%-ийг төсвийн санхүүжилтээр 20%-ийг малчин өрх төлөхөөр, 2/Баянхонгро аймгийн 4 сум, Архангай - Булган, Хайрхан, Төвшрүүлэх, Хотонт, Эрдэнэмандал, Өвөрхангай - Богд, Уянга, Хайрхандулаан, Есөн зүйл, Хархорин, Хужирт/ нийт 31261 айл өрхийг зориулалтын бус хуванцар савыг /нэг өрхөд 2 ширхэг 20литрийн сав, 1 ширхэг 60 литрийн сав/ 20литр - 20.000төг, 60 литр - 45.000 төгрөгийн зориулалтын савын үнийг 50 хувь хөнгөлж, нэг өрхөд 42.500 төгрөгийн хөнгөлөлт үзүүлэхээр зардлыг тус тус тооцож, төрийн бус байгууллага эсхүл сонгон шалгаруулалт явуулж, шалгаруулалтад тэнцсэн байгууллага хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн зөөвөрлөх, хадгалахад ашиглаж байгаа зориулалтын бус савыг зориулалтын саваар солих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхээр санал боловсруулж, ХХААХҮЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын газарт удаа дараа хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. Хавсралт: 1 файл	30%
3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх					
23	3.1. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, шинэ технологи бүхий сав, баглаа боодлын эко үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжих;	2017 - 2021	ЖДҮХС, СХС-1,207.3 сая төг, Хувийн хэвшил-120.0 сая төг	Тайлант 2020 онд: ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд ЖДҮХС-аас 2020 онд хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлд сав баглаа боодол үйлдвэрлэгчдийг оруулах саналыг хүргүүлэн, ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны А-131 дугаар тушаалаар батлуулж, 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар сав, баглаа боодлын үйлдвэрлэлийн 7 ААН-д 1,060.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Мөн Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци цаасан сав баглаа боодлын үйлдвэрт 70 сая, Зуунмод сумын СХС-аас 2 ААН-д 30.5 сая, Дундговь аймгийн СХС-аас хүнсний зориулалтын цаасан тор, уут үйлдвэрлэгч иргэнд 30 сая, Дархан-Уул аймаг СХС-аас Бурхантын бүтээлч бүсгүйчүүд хоршооны давуун тор, уутны үйлдвэрлэлд 15.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2019 оны 12/04 дугаар тогтоолоор 2020 оныг “Өвөрхангайд үйлдвэрлэв” жил болгон зарлаж, эхний ээлжинд 1 ААН-д өндөгний савлагаанд 1.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. “Шинэ хөдөө Булган” төслөөс сүүний хөргүүртэй контейнерт сүү зөөвөрлөх зориулалт бүхий 35 ширхэг 40 литрийн	100%

				бидоныг олгосон. Сүхбаатар аймагт “Тэнүүн билиг арвижих” ХХК нь 120.0 сая төгрөгийн өөрийн санхүүжилтээр 40000 шир/сар цаасан уут үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг байгуулж, 3 хүнийг ажлын байраар хангасан.	
24	3.2. Уламжлалт модон торх, ган, хувин, ширэн хөхүүр, гоёл чимэглэлийн уут, савны урлалыг дэмжиж брэнд болгох ажлыг орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулах, давуун болон цаасан тор, уутны хэрэглээг дэмжих;	2017 - 2021	80.0 сая төг	- Дундговь аймгийн уламжлалт модон хувин, торх үйлдвэрлэгч ТЭББЭ ХХК нь 2018 онд ЖДҮХСангаас 300,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, хүчин чадлаа 35 % нэмэгдүүлсэн. Үйлдвэрлэлт 2017 онтой харьцуулахад 2-3 дахин нэмэгдэж Дундговь, Баянхонгор, Өмнөговь, УБ хотод борлуулалтын цэгээ нээсэн. Орхон аймгийн уламжлалт модон эдлэлийн Дэнж бадрах ХХК орон нутгийн ЖДҮ-ийг дэмжих тусгай сангаас 20,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, үйлдвэрлэлээ өргөжүүлэн, нэр төрлөө нэмэгдүүлсэн. Төв аймагт сав баглаа боодлын 3 цех шинээр байгуулагдаж, 150-300 ш модон торх-хувин, 70-90 ш айрагны хөхүүр, 80 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл 2 ААН-д олгогдон 1500 ш давуун болон цаасан тор үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна. - Баян-Өлгий аймгийн ЗДТГ "Хөдөө аж ахуйн ажилтны зөвлөгөөн", "Тогооч нарын анхдугаар зөвлөгөөн"-д оролцогч 289 иргэнд гялгар уутны хор холбогдлын тухай сургалт зохион байгуулж, 400000 төгрөгийн төсвөөр давуун уут оёулан, тарааж, сумдад уг ажлыг үргэлжүүлэн ажиллахыг уриалав. Хэнтий аймгийн Хэрлэн, Биндэр суманд “Цаасан болон давуун торыг ашиглацгаая” уриалга гарган, 24 хүнсний дэлгүүр давуун тороор үйлчилж, түргэн хоолны газрууд цаасан уутыг хэрэглээндээ нэвтрүүлээд байна. Орхон аймгийн Хатан төрх ХХК, Уран сархиа ХХК нь гялгар уутны хэрэглээг халах зорилгоор давуун тор, уутыг оёж зах зээлд нийлүүлж эхлээд байна. Сэлэнгэ аймагт “Давуун уутны бүтээлийн уралдаан” зохион байгуулж, 17 сумын 40 оёдолчдоос 100 гаруй нэр төрлийн уут ирүүлснээс 1-т “Зүүнхараа хувцас урлан”, 2-т О.Наранчимэг, 3-т “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд” ТББ-ын бүтээлүүд тус тус шалгарч, аймгийн томоохон худалдаа үйлчилгээний газруудаар худалдаалж 23,5 сая төгрөгийн борлуулалт хийсэн. - Глобол коммуникэйшн ОУБ-ын захиалгаар давуун тор, уутыг үйлдвэрлэж нийлүүлснээр Дархан-Уул аймгийн гэр хорооллын 5 багийн 45 иргэнд олгосон. Орон нутагт 1 үйлдвэр шуудай, хэвлэлийн 7 үйлдвэр цаасан уут, хаяг шошгыг, оёдлын нэг хоршоо давуун тор, уутыг үйлдвэрлэж, иргэд, албан байгууллагад нийлүүлж байна.	90%
25	3.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд чанар, стандарт, загвар дизайны шаардлага хангасан дотоодын сав, баглаа боодол, хаяг шошго хэрэглэхийг төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд уриалж, энэ чиглэлээр явуулж байгаа сурталчилгаа, маркетингийн үйл	2017 - 2021		Нийслэлийн хүн амын 2020 оны хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махны сав, баглаа боодлын хаяг, шошгын нэгдсэн загварыг холбогдох байгууллагуудтай хамтран шинэчилсэн. Бэлтгэн нийлүүлэгч ААН-дэд ОБ пластик ХХК-ийн хүчин чадал, уутны нөөц, үнийн мэдээллийг танилцуулж, эрүүл ахуйн шаардлага хангасан уут, баглаа боодол хэрэглэхийг уриалж, үндэсний үйлдвэрлэгчээ дэмжин ажилласан. - Баян-Өлгий аймагт зориулалтын бус савны хөр хөнөөлийг иргэдэд хүргэх зорилгоор Финпак ХХК, Дэлхийн зөн, Жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо, ХАҮТ, Хоол үйлдвэрлэгчдийн Галайхан холбоотой хамтран 5 удаагийн сургалт явуулсан. ЗД-н А/245 дугаар захирамжаар 04.15-05.15-ны өдрүүдэд “Эрүүл хүнс” сарын аяныг зохион байгуулж, хуванцар савгүй аймаг, сум, баг хөдөлгөөнийг өрнүүлэн уриалга гарган, хуванцар савыг хэрэглээнээсээ халсан 3 сумыг шагнан урамшуулсан. Сүхбаатар, Дундговь аймгийн сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд, хүнсний 150 гаруй ААН-ийн 450 хүнд хөх сав, канистераас татгалзах, эко савны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, гарын авлага тараасан. - Хэнтий аймгийн 18 суманд стандартын шаардлага хангасан сав баглаа боодол хэрэглэхийг уриалж, хүнсний аюулгүй сав - түүний хэрэглээ, таних аргууд, зориулалтын бус савнаас татгалзах, сав баглаа боодлын стандарт зэрэг таниулах хуудас, гарын авлага бэлтгэн аймаг, сумын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр сурталчлан ажилласан. Завхан, Сэлэнгэ аймгийн 24 суманд хуванцар сав, гялгар уутны хэрэглээ, хор нөлөөллийн талаар зөвлөмж, гарын авлага	90%

	ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;			бэлтгэн 2500 ширхгийг тараасан. Булган аймгийн ТВ, цахим хуудсаар дамжуулан хоол үйлдвэрлэлийн газруудад цаасан уут, иргэдийн ахуйн хэрэглэнд зориулалтын хуванцар савыг хэрэглэж хэвшүүлэх талаар уриалсан. Дархан-Уул аймаг хүнсний сав, баглаа боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, сэрэмжлүүлгийг 4 ТВ, цахим сайтаар түгээж, 87 иргэнд нийлэг уутны, 15 цэцэрлэгийн багш, эцэг эхчүүдэд хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээ, хор хөнөөлийн талаар зөвлөмж өгсөн.	
26	3.4. Монгол Улсад үйлдвэрлэх боломжтой сав, баглаа боодлын нэр, төрөл, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа явуулах, сав, баглаа боодлын үндсэн түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих, цаас, шил, төмөр сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, арга замыг судалж шийдвэрлэх;	2017 - 2021		ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны А-131 дугаар тушаалаар ЖДҮХСангаас 2020 онд хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлд сав баглаа боодол үйлдвэрлэгчдийг оруулах саналыг хүргүүлэн батлуулж, 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар сав, баглаа боодол үйлдвэрлэлийн 7 аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлд хамруулан, нийт 1,060,200,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Дотоодод үйлдвэрлэх боломжтой сав, баглаа боодлын нэр, төрөл, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа явуулах, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, арга замыг судлах судалгааны ажлыг 2021 онд гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөн 2021 төсвийн төсөлд санал боловсруулан хүргүүлээд байна. - Химийн зориулалттай хуванцар савны хэрэглээний бодит түвшинг тогтоох судалгааны зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А-299 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт Хүнсний үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн 1.4-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. ХҮҮБХЗГ-тай хамтран “Монгол улсын хүн амын ахуйн хэрэглэнд ашиглаж буй хүнсний бус зориулалтын савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааны ажлыг гүйцэтгэх” гэрээг Монголын Хүнсчдийн Холбоотой байгуулж, судалгааны ажлын тайлан, холбогдох материалыг хүлээн авсан. - Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнс хоол үйлдвэрлэлийн салбарт ашиглагдаж байгаа сав баглааны нэр төрөл, тоо хэмжээ, хэрэгцээг судалж байна. Цаашид судалгааны дүнд үндэслэн сав баглаа боодлын үйлдвэрлэлийг тэргүүлэх чиглэлийн нэг болгон хөгжүүлэх боломжтой эсэх талаар судалж, дэмжлэг үзүүлэх эрхзүйн орчин бүрдүүлэх чиглэлийг баримтлан ажиллана.	70%
27	3.5. Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, бусад салбартай хоршин ажиллах боломжийг тодорхойлох үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой байгуулж үйл ажиллагааг нь дэмжих;	2017 - 2021		ЗГ-ын 2016 оны 287-р тогтоолоор батлагдсан "Сав баглаа боодол" үндэсний хөтөлбөрийг хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХААХҮСайдын 2019 оны А-138 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг 28 арга хэмжээний хүрээнд төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэлийг хөнгөн үйлдвэрлэлийн бусад салбар болон мах, сүүний салбартай хэрхэн хоршин, хамтран ажиллах тухай "Хүнсний бүтээгдэхүүний савлагаа-брэндинг, маркетинг" сургалтыг 2019 оны 08-р сард зохион байгуулсан. - Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махны сав, баглаа боодлын хаяг, шошгын нэгдсэн загварыг холбогдох байгууллагуудтай хамтран санал солилцон шинэчлэн гаргасан. Үндэсний үйлдвэрлэгч дотоодын сав баглаа боодлын үйлдвэрүүдийг судлан, бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд ОБ пластик ХХК-ийн уут, сав баглаа боодлын үнэ, нөөц, үйлдвэрийн хүчин чадал зэргийг ганилцуулж, хүнсний зориулалттай, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан уут, сав баглаа боодлыг сонгон хэрэглэхийг уриалж, үндэсний үйлдвэрлэгчээ дэмжин ажилласан. - Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний 105 үйлдвэрүүдээс сав, баглаа боодлын хэрэглээний судалгааг авахад Улаанбаатар хотын ОБ пластик ХХК, Солонго пресс ХХК, Омега ХХК, ЗДМ ХХК, Эко Пак ХХК зэрэг сав баглаа боодлын үйлдвэрүүдээс шуудай, хиамны бүрхэвч хальс, цаасан уут, хаяг шошго, зориулалтын	90%

				гялгар уутыг татдаг тооцоо гарсан. Хөвсгөл аймгийн талх гурилан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ үйлдвэрлэж буй үйлдвэрүүд УБ хотын Об Пресс ХХК, Эко Пак ХХК-аас хаяг шошго, бялууны хайрцаг зэрэг сав баглаа боодлоо авч ашиглаж байна. “Адра Монгол” ОУБ-аас Сэлэнгэ аймгийн Зөгийн аж ахуй эрхлэгч хоршоодод стандартын шаардлага хангасан шилэн савнуудыг нийлүүлсэн.	
28	3.6. Олон улсын сав, баглаа боодлын холбоонд гишүүнээр элсэх боломжийг судалж шийдвэрлэх;	2017 - 2021		Дэлхийн Сав баглаа боодлын байгууллага (ДСБББ)-ын Удирдах Зөвлөлийн хуралдаанд холбооны гишүүн 53 орны төлөөлөгчид 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр оролцож, Монголын Сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоог бүрэн саналын эрхтэй гишүүнээр элсүүлэхийг 97 хувийн саналаар дэмжлээ. Хуралдаанаар ДСБББ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох, гишүүнээр элсүүлэх улс орнуудын асуудлыг хэлэлцэв. Дэлхийн Сав баглаа боодлын байгууллага нь 1968 онд байгуулагдсан ашгийн бус, аль нэг улсын Засгийн газарт хамаардаггүй, үндэсний болон бүс нутгийн сав баглаа боодлын хүрээлэн, холбоод болон бусад хамааралтай корпорациуд, худалдааны холбоодыг нэгтгэсэн байгууллага юм. НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд Дэлхийн Сав баглаа боодлын байгууллага, Монголын Сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монголын Хүнсчдийн холбоо хамтран “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа, боодол ба брендинг-маркетинг” сэдэвт олон улсын VI модуль сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 27, 29-ний өдөр зохион байгуулсан юм. Энэхүү сургалтын үеэр Дэлхийн сав баглаа боодлын холбооны гишүүн болох асуудлыг хөндөн ярилцсан нь ийнхүү биелэлээ оллоо.	100%
29	3.7. Дотоодын сав, баглаа боодол, хаяг шошгыг тогтмол хэрэглэгч, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжүүдийг жил бүр шалгаруулж урамшуулдаг болох	2017 - 2021		Дотоодын сав, баглаа боодол, хаяг шошгыг тогтмол хэрэглэгч, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжийг урамшуулах "Мөнгөн богц" арга хэмжээг зохион байгуулах зардал нь Коронавирусийн халдвар дэгдэж цар тахлын хэмжээнд хүрсэнтэй холбогдуулан СЯ-аас тэвчиж болох зардлын ангилалд оруулсан. ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А-299 дугаар тушаалын Хүнсний үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн 1.4-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэн 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, хөтөлбөр, төсвийг агуулсан ХХААХҮЯ-ны ТНБД-ын тушаалын төслийг боловсруулсан боловч, Ковид-19-ийн нөхцөл байдалтай холбоотой тэвчиж болох зардлын ангилалд хамааруулсан тул СХОГ-аас санхүүжүүлэх боломжгүй гэсэн чиглэл өгсөн. МУЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор тус арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болоод байна. - Орон нутгийн хэмжээнд “Мөнгөн богц” уралдааны удирдамж боловсруулан Сүхбаатар аймгийн бүх сумдад хүргүүлж, 12 төрлийн цагаан идээний хайрцаг, сав үйлдвэрлэсэн иргэн, цаасан уут, даавуун тор үйлдвэрлэсэн “Тэлмүүн гүн” ХХК, цагаан идээ савлах хайрцаг үйлдвэрлэсэн Түвшинширээ сумын малчныг тус тус байр эзлүүлж, урамшуулсан. Төв аймгийн Аргалант сумын модон торх үйлдвэрлэгч Мөнгөн богц шагналыг хүртсэн бөгөөд 10.0 сая төгрөгийн зээл олгох шийдвэр гарсан. Өмнөговь аймгийн “Мөнгөн богц” уралдаанд 9 аж ахуй нэгж, иргэн оролцсоноос 2 аж нэгжийг шалгаруулан урамшуулж, цаашид борлуулалт хийх уул уурхайн компани, томоохон хүнсний худалдаа эрхлэгчидтэй холбож өгөв. - Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 ААН-д “Нийгмийн хариуцлагатай, дотоодын сав баглаа боодол хаяг шошгыг тогтмол хэрэглэгч” талархлын бичиг гардуулж, урамшуулсан.	70%
	Дундаж үнэлгээ				83.79